



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/33

Тавин

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 06 сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Ар-Урт, Өвөр-Урт, Сүм, Хашаат багуудад худгийн цооног шинээр барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга: Д.Нямсүрэн (Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: О.Ганбаатар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүд: Г.Баасанжав (Хүний нөөцийн мэргэжилтэн)
Б.Мижиддорж (Сайнцагаан сумын Багийн Засаг дарга)

Х.Туяажаргал (Иргэний төлөөлөл)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Нямсүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ч.УРАНЧИМЭГ

